



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 1/643

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газарт Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн УТ2403100363 дугаар бүхий Фитнесийн тоног төхөөрөмж худалдан авч нийлүүлэх ажил хийгдсэн тул хүлээн авч, ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                       |                 |  |
|-----------------------|-----------------|--|
| Комиссын дарга:       | Ж.Амгаланбаатар | (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)                                   |
| Гишүүдэд:             | Р.Наранбаатар   | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэнд, спорт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан мэргэжилтэн) |
|                       | Ж.Эрхбаяр       | (Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн)  |
|                       | Г.Билэгсайхан   | (Орон нутгийн өмчийн газрын Бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)                                 |
|                       | Б.Магнайбаяр    | (Биеийн тамир спортын газрын ахлах мэргэжилтэн)  |
| Нарийн бичгийн дарга: | Н.Золжаргал     | (Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын менежер)   |

2. Гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар (Ч.Батдэлгэр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ